

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитыг Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2018 оны А/06 дугаар тушаалаар батлагдсан “Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын сэдвийн төлөвлөгөө”-г үндэслэн өөрийн байгууллагын санаачилгаар Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт:

Аймгийн нэгдсэн эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүртээмж, чанар, хөрөнгө оруулалтаар олгогдсон тоног төхөөрөмжийн үрдүнд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийнэ. Үүнд:

- Байгууллагын орон тоо, мэргэжлийн боловсон хүчнийг хэрхэн сонгож томилж байгаа байдал, мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан эсэх
- Аймгийн нэгдсэн эмнэлгийн тусламж, үйлчилгээний хамралт, хүртээмж, үйл ажиллагаанд нөлөөлөх хүндрэл бэрхшээл
- 2017 онд хөрөнгө оруулалтаар олгогдсон тоног төхөөрөмжийн ашиглалт, үр дүн

Хамарсан хүрээ:

ЭМЯ-аас гаргасан тогтоол, шийдвэр, зөвлөмжийн хүрээнд Аймгийн нэгдсэн эмнэлэгийн үйл ажиллагааг хамруулаа.

Аргазүй:

Аудитыг гүйцэтгэхэд Нийцлийн аудитын удирдамж АДБОУС 4000-4200, нийцлийн аудитын журмыг ашиглах бөгөөд 2017 онд гаргасан журам, дүрэм, шийдвэр, батлагдсан орон тоо, гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, хандив тусламжаар нийлүүлэгдсэн хөрөнгийн судалгаа, ашиглалт, хүний нөөцийн бүртгэл, тасгуудын ажлын тайланг судлах, шалгагдагч байгууллагын холбогдох албан тушаалтан нартай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, нөхцөл байдлын шинжилгээхийж аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйлцуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулаа.

Энэхүү аудитыг хийхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, нийцлийн аудитын журмыг баримталсан бөгөөд журамд заасны дагуу аудитын дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох бусад мэдээллийг ажлын баримт материалд хавсаргав.

Бүлэг 1. Нэгдсэн эмнэлгүүдэд мөрдөх бүтэц үйл ажиллагааны стандартын хэрэгжилт 68,7 хувьтай байна.

Эрүүл мэндийн яам 2017онд аймгийн Нэгдсэн эмнэлгийг 279 орон тоотойгоор ажиллахаар баталжээ.

Орон тоо, бүтцийг судлаж үзэхэд батлагдсан орон тооноос удирдах 1, гүйцэтгэх 24 нийт 25 ажилтан илүү авч ажиллуулсан байна. /Судалгаа 1/

Илүү ажилласан орон тоог аймгийн Нэгдсэн эмнэлгийн даргын 2017оны 02 дугаар сарын 23 –ны А/49 тоот тушаалын хавсралтаар шинэчлэн гарган баталж, мөрдөн ажилласан нь харъя яамны сайдын гаргасан тушаалыг зөрчсөн байна.

Нэгдсэн эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны MNS-5095-2013 стандартаар нийт 442 эмч, ажилчид ажиллахаас нэгдсэн эмнэлгийн даргын тушаалаар 304 ажилтанг батлан ажиллуулсан нь уг стандартын хэрэгжилтийн 68,7 хувь байна.

Дээрх байдлаас дүгнэлт хийхэд Эрүүл мэндийн яам нэгдсэн эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны MNS-5095-2013 стандартыг харгалзан үзэлгүй орон тоог баталжээ.

Аудитын явцад эмч, эмнэлгийн ажилтнуудын ажил эрхлэлтийн байдлыг судлан үзэхэд нэн шаардлагатай тусламж үйлчилгээг жилд дунджаар 12 эмч, эмнэлгийн ажилтан хавсран гүйцэтгэж нэмэгдэл хөлс авч байгаа нь зайлшгүй ажиллуулах эмч эмнэлгийн ажилтан хэрэгтэй байгааг харуулж байна гэж үзлээ.

Мөн эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж байгаа тасгуудын ажлын ачаалалыг судлан үзэхэд Мэдээгүйжүүлэх эрчимт эмчилгээ, яаралтай тусламжын тасагт ажиллаж байгаа ээлжийн сувилагч, үйлчлэгч яаралтай тусламжийн 103 тоот суурин утсыг ажиллуулдаг, өндөр насны тэтгэвэрт гарсан эмч нар халдвар судлагч, бөөрний их эмчийн ажлыг хийж байна.

Эдгээр байдлууд нь эмчилгээ үйлчилгээний чанар, хүртээмжид сөрөг нөлөө үзүүлэх магадлал өндөр байгааг харуулж байна.

Мөн бодит байдлаас ажиглахад хүүхдийн тасагт үзүүлэх яаралтай болон эрчимтэй эмчилгээний тусгай тасаг ажиллуулах хэрэгцээ шаардлага ажиглагдаж байна.

Иймд харъяа яамандаа хэрэгцээтэй, шаардлагатай орон тоог нэмэглүүлэх саналыг хүргүүлэн шийдвэрлүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Тайлант онд шинээр мэргэшүүлэх болон давтан сургалтанд хамрагдсан их эмч 8, сувилагч 3, сувилахуйн арга зүйч, механик, тоног төхөөрөмж болон сүлжээний инженер тус бүр 1-ийг авч ажиллуулсан байна.

Ажилд орохыг хүссэн их эмч болон эмнэлгийн мэргэжилтнүүдийг ажилд авахдаа дотоод журманд заасны дагуу ажилд орохыг хүссэн хүсэлтийг хүний нөөцийн менежер хүлээн авч, ажлын байрны тодорхойлолтонд заасан шаардлагыг хангасан бол ерөнхий эмчид танилцуулан шийдвэрлэжээ.

Сувилагч, тусгай мэргэжилтэнг ажилд авахдаа сувилагааны албаны удирдах зөвлөлийн шийдвэр саналыг харгалзан бүрдүүлэх материалыг бүрэн хянан, дадлагажигч ангийн хөтөлбөрт хамруулан онолын болон дадлага ажлын шалгалт авч Сувилгааны албаны дүрмийн 3,4-т заасан заалтын дагуу сонгон шалгаруулалт явуулан шалгалтанд тэнцсэн ажилтануудыг авч ажиллуулжээ.

Ажилчдыг ажилд авахдаа хөдөлмөрийн дотоод болон бусад журманд заасны дагуу сонгон шалгаруулалт хийж бүрдүүлэх материалыг бүрэн хянан авч ажиллуулсан байна.

Бүлэг 2. Тус эмнэлэг нь Эмнэлэгийн тусламж үйлчилгээний тухай хуулийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2.1. 2017 онд эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлэх 14 амбулатори, хэвтэн эмчлүүлэх 11 тасаг, үйл оношлогоо, нөхөн сэргээх эмчилгээ, эмгэг судлал, цусны салбар банк, дүн бүртгэл, эмнэлгийн эмийн сан гэх мэт параклиник болон санхүү,аж ахуй, гал тогоо, авто граж, инженер техник засвар үйлчилгээ,угаалга, ариутгал, хог хаягдал,харуул хамгаалалт бүхий дэмжих үйлчилгээний хэсгүүдтэй ажилласан байна.

Хуучин ажиллаж байсан бүтцийг нэгдсэн эмнэлгийн даргын 2017 оны А/25 тоот тушаалаар лабортори,оношзүйн тасгуудыг нэгтгэн үйл оношлогооны тасгийг, сүрьеэ,халдвартын тасгуудыг нэгтгэн халдварт сүрьеэгийн тасгийг ажилуулахаар өөрчилжээ.

Нэгдсэн эмнэлгийн дарга нь Эрүүл мэндийн газрын даргын болон Аймгийн засаг даргын бүтцэд өөрчлөлт оруулах шийдвэр гараагүй байхад дээрх тушаал гаргасан нь Эрүүл мэндийн тухай хуулийн 12.1.1/эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газар, нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг даргаас гаргасан шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах/ гэсэн заалттай нийцэхгүй байна.

Нэгдсэн эмнэлэгийн удирдлагаас хяналт-шинжилгээ, үнэлгээний багийг томилсон боловч,эрх үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Тус нэгдсэн эмнэлэг нь “Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна. Шалтгааныг тодруулахад :

1. Энэ хуулийг улсын хэмжээгээр бүрэн мөрдөж ажиллаагүй бөгөөд Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр 3 аймагт туршиж үр дүнг тооцож байгаа
2. Хуулийг дагаж гарах журмуудаас Өрхийн эрүүл мэндийн дүрмийг шинэчлэн батлахаас бусад дүрэм, журам гаргаагүйтэй холбоотой байна. Тухайлбал: тус хуулийн
 - 8.3./Эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын тусламж, үйлчилгээний жагсаалт, журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална/
 - 9.4.Эх барихын тусламж, үйлчилгээнд мөрдөх заавар, үр хөндөх, жирэмслэлтийг таслах ажилбар гүйцэтгэх журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
 - 10.3.Эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх үйлчлүүлэгчийг эрэмбэлэх болон яаралтай тусламжийг зохион байгуулахтай холбогдох заавар, журам, маягтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална
 - 11.3.Түргэн тусламжийн үйлчилгээний зохион байгуулалт, үйлчлэх хүрээг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмаар зохицуулна
 - Сувилахуйн болон хөнгөвчлөх, асаргаа сувилгааны төвийг байгуулах журам, үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт, сувилахуйн төв, хөнгөвчлөх, асаргаа, сувилгааны төвд илгээх үйлчлүүлэгчийн өвчин эмгэгийн жагсаалтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
 - Сэргээн засах төв, сувилал байгуулах, үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт, журам болон сувилал, сэргээн засах төвд илгээх үйлчлүүлэгчийн өвчин эмгэгийн жагсаалтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний урамшууллын жишиг хэмжээ, олгох журмыг санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.
 - Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн болон тусгай эмнэлэг, амаржих газар, клиник нь энэ хуулийн 18.1, 18.2-т заасан тусламж, үйлчилгээг гэрээний дагуу урьдчилсан санхүүжилт авч гүйцэтгэх бөгөөд санхүүжилт авах журам, гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална гэсэн

заалтуудад дурьдсан дүрэм, журам хараахан гараагүй байна.

2.2 Чанарын алба нь мэдээлэлийг түгээх болон хяналт тавих чиг үүргээ хангалттай биелүүлээгүй байна.



2017 онд нэгдсэн эмнэлэг нь амбулаторын үзлэгт 86592 иргэнд эмнэлэгийн тусламж үйлчилгээ үзүүлсэний 31452 иргэн нь сумаас ирж үйлчлүүлсэн, эмнэлэгт 5932 иргэн хэвтэн эмчлүүлсний 2686 иргэн нь хөдөө орон нутгаас ирж үйлчлүүлжээ.

2017 онд чанарын алба нь “Иргэдэд ээлтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээ” уриан дор 6 бүлэг 77 заалт бүхий жилийн ажлын боловсруулан биелэлтийг тооцон ажиллажээ. Тусгагдсан ажлуудаас 66 ажлуудыг хэрэгжүүлсэн, 11 ажлыг огт хэрэгжүүлээгүй байна.





Чанарын албаны үйл ажиллагааны тайлан болон холбогдох нотлох баримтуудаас дүгнэхэд дараах дутагдал ажиглагдлаа.

- Чанарын хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгч үр дүнг тооцоогүй
- Чанарын ажлын төлөвлөгөөний биелэлтэд дүн дүгнэлт өгдөггүй, хэрэгжилтийг тооцож ажилаагүй байна.
- Хүний нөөцийг хөгжүүлэх, дадлагажуулах, чадавхыг дээшлүүлж байгаа байдалд хяналт тавьж ажиллаагүй
- Цус, цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, хадгалалт, зарцуулалтад хяналт тавиагүй
- Тусламж үйлчилгээний чанарын мэдээллийн сан байгуулж ажиллаагүй
- Байгууллагын цахим хуудсанд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаар мэдээлэл тавих, хамтын мэдээлэл солилцох, суралцах талаар ажил зохион байгуулаагүй
- Төлөвлөгөө боловсруулахдаа хэрэгжүүлэх үйл ажиллагааг дүрэмд заасан чиглэлд уялдуулан системтэйгээр төлөвлөдөггүй.
- Хэрэгжүүлсэн зарим арга хэмжээг нотлох баримтаар баримтжуулаагүй

2.3 Аймгийн нэгдсэн эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлсэн эрүүл мэндийн чанарт нөлөөлөх гол үзүүлэлт эерэг дүнтэй байна.



Аймгийн нэгдсэн эмнэлэгийнэрүүл мэндийн үйлчилгээний чанар, хөрөнгө оруулалтаар олгогдсон тоног төхөөрөмжийн ашиглалт, үр дүн /2017 он/



Статистик үзүүлэлтээс дүгнэхэд: 2017 онд Улиастай сумын хүн амын тоо 2015 оноос 906-аар өссөн, амьгүй төрсөн хүүхдийн тоо 3-аар буурсан, төрсөн эхчүүдийн жрэмсний хүндрэл 11-ээр буурсан, төрөхийн хүндрэл 122-оор буурсан, нэг хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 13-аар буурсан, эмнэлэгт нас барсан хүний тоо 8-аар буурсан, амбулаторын үзлэг 11695-аар нэмэгдсэн, зэрэг өссөн үзүүлэлттэй байна.

Тус эмнэлэг нь эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүрээмжийг сайжруулах зорилгоор дараах арга хэмжээ авч ажилласан байна.

- Тайвань улсын засгийн газрын санхүүжилтээр бөөрний диализын 2 аппарат нийлүүлэгдсэн.
- Мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээний тасагт гемодиализын тасгийг нээн ажиллуулсан.
- Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр ЭМХХ-5 төслөөс цусны салбар банкны иж бүрэн засвар хийж, тоног төхөөрөмж суурилуулсан
- Амбулаторийн үзлэгийн болон үйл оношийн кабинетууд тухайн өдөрт ногдох үзлэгийн тооноос илүү гарган үзлэг хийсэн

- Гемодиализ, эрчимт эмчилгээ, яаралтай туслажийн хэсгүүдийн өрөө байрыг тусад нь зохион байгуулж, яаралтай тусламжийн бэлэн байдал стандартыг ханган ажилласан.

Дээрхээс дүгнэхэд нэгдсэн эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмж, өмнөх онуудаас нэмэгдсэн байна гэж үзэх үндэстэй байна

В.1 Хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн хөрөнгүүд нь орчин үеийн шинэлэг бөгөөд, орон нутгийн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангаж байна.

2017 онд аймгийн нэгдсэн эмнэлэгт хандив тусламж болон улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 345,5 сая төгрөгийндоорх төсөл арга хэмжээнүүд хэрэгжжээ.

Д/д	Төсөл арга хэмжээний нэр	Төсөл арга хэмжээний дүн / сая төгрөгөөр /	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр
1	Мэс заслын тасгийн их засвар	119,9	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
2	Авто тээврийн хэрэгсэл	24,5	Хандив тусламж, балансаас балансад шилжүүлсэн
3	Машин тоног төхөөрөмж	187,4	Дэлхийн зөн Завханхангай ОНХХ Баян айраг эксплорэйшн улсын төсвийн хөрөнгө оруулалт
4	Тавилга, эд хогшил	13,7	Дэлхийн зөн Завханхангай ОНХХ орон нутгийн хөгжлийн сан
Дүн		345,5	

Мэс заслын тасагт урсгал засвар хийгдээгүй олон жил болсон тул тайлант оны их засварын ажил нь эмнэлгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн байна гэж үзлээ.



Нэгдсэн эмнэлэгт тайлант оны эхэнд 11 автотээврийн хэрэгсэл ашиглагдаж байснаас аймгийн ИТХ-ын шийдвэрээр 4 авто тээврийн хэрэгсэл актлагдсан тул хандиваар нийлүүлэгдсэн 18,0 сая төгрөгийн өртөгтэй Delica маркийн микробус, аймгийн ИТХ-ын шийдвэрээр Тэс сумын эрүүл мэндийн төвөөс балансаас балансад шилжүүлэн авсан 6,5 сая төгрөгийн өртөгтэй УАЗ 315122 маркийн суудлын автомашин зэрэг нь эмнэлгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн бөгөөд ойрын дуудлагад ашиглагдаж байна.



Тайлант онд “Баян айраг эксплорэйшн” ХХК-аас 3 нэр төрлийн 12,0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллагын Завханхангай хөгжлийн хөтөлбөрөөс 4 нэр төрлийн 7,9 сая төгрөгийн тоног төхөөрөмжүүдийг хандивласан, Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар 6 нэр төрлийн 137,4 сая төгрөгийн тоног төхөөрөмж, аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас 1 нэр төрлийн 30,0 сая төгрөгийн тоног төхөөрөмж тус тус нийлүүлэгдэн, нэгдсэн эмнэлэг нь төсвийн хөрөнгөөрөө 4 нэр төрлийн 22,5 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг худалдан авсан байна.



Эмнэлгийн удирдлагууд “Баян айраг эксплорэйшн” ХХК, Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллагын Завханхангай хөгжлийн хөтөлбөр, аймгийн ИТХ-ын дарга, аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн яаманд хүсэлт тавьсны үр дүнд хэрэгцээ шаардлагад нийцсэн тоног төхөөрөмжүүдээр тодорхой хэмжээнд хангагдсан байна.

Аудитаар тоног төхөөрөмжийн 2017 оны тооллогын бүртгэл, эрүүл мэндийн салбарын эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн нэгдсэн сангийн бүртгэл, “Нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа” MNS 5095-2017 стандартад заагдсан нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн жагсаалт зэргийг судлаад 2017 онд нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжүүдийг эмнэлгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн байна гэж үзлээ.

Тоног төхөөрөмж хуваарилагдсан тасгийн эмч, техникч нар, тоног төхөөрөмжийн инженертэй ярилцлага хийхэд тайлант онд нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийг орчин үеийн шаардлагад нийцэж байгаа гэсэн тайлбарыг өглөө.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас 11,2 сая төгрөгийн эмнэлгийн ор, шүүгээний хамт, Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллагын Завханхангай хөгжлийн хөтөлбөрөөс 10 нэр төрлийн 2,5 сая төгрөгийн тавилгыг тус тус хандивласан байна.


В.2 Хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, ашиглалтыг хариуцах инженер, техникийн ажилтнаар хангагдсан ч ажлын ачаалал харилцан адилгүй байна.

“Нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа” MNS 5095-2013 стандартад тоног төхөөрөмжийн инженер 4, техникч 2 ажиллана гэж тогтоосон боловч эмнэлгийн удирдлагаас 1 тоног төхөөрөмжийн инженер, 3 техникч, 2 мэдээлэл технологийн ажилтан ажиллахаар орон тоог баталжээ.

Бодит байдалд 2 тоног төхөөрөмжийн инженер, 2 мэдээлэл технологийн ажилтан, томографийн болон рентгэн туяаны тоног төхөөрөмжийн 3 техникч ажилладаг, 2017 оны 5 сараас тоног төхөөрөмжийн 1 инженерт диализийн техникчийг хавсруулан ажиллуулсан байна. Эндээс харахад эмнэлгийн удирдлагын баталсан орон тооноос 1 инженерийн орон тоо хэтэрсэн байна.

Инженерүүдийн ажлын ачааллыг хариуцсан үндсэн хөрөнгийн тоо хэмжээнээс хамааруулан авч үзвэл харилцан адилгүй байна. Тухайлбал:1 тоног төхөөрөмжийн инженер нь зөвхөн 83,8 сая төгрөгийн өртөг бүхий диализын аппарат, ус цэвэршүүлэх системийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хариуцан, засвар үйлчилгээг нь хийдэг,мэдээллийн технологийн 2 ажилтан нь 84 нэр төрлийн 384,6 сая төгрөгийн мэдээллийн технологийн тоног төхөөрөмж, 7 нэр төрлийн 22,7 сая төгрөгийн программ хангамжийн хэвийн үйл ажиллагааг хариуцдаг бол нөгөө тоног төхөөрөмжийн инженер нь 545 нэр төрлийн 4492,0 сая төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмжүүдийн засвар үйлчилгээг хариуцан ажиллажээ.

Эмнэлгийн тоног төхөөрөмжүүдийн ашиглалтанд орсон хугацаа, болон ашиглалтын байдлыг авч үзвэл доорх байдалтай байгаа бөгөөд эвдрэл гэмтлээс шалтгаалан тоног төхөөрөмжийн зөвхөн 2 хувь нь ашиглагдаагүй байна.



Эмнэлгийн тоног төхөөрөмжийн 4,1 хувийг 1978-2007 онуудад ашиглалтанд орсон 89 нэр төрлийн 185,0 сая төгрөгийн тоног төхөөрөмж эзэлж байгаа бөгөөд эдгээр нь анагаах ухааны хөгжил дэвшлээс хоцрогдсон, ашиглалтын хугацаа нь дууссан тул байнгын засвар үйлчилгээг шаарддаг.

Мөн эмнэлгийн тоног төхөөрөмжийн 80 хувь нь сүүлийн 5 жилийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн бөгөөд эмнэлгийн удирдлагууд тоног төхөөрөмжийг ажиллуулах эмч, техникчийг бэлтгэснээр бүрэн ашиглах нөхцөл бүрдэж, ээлжит засвар үйлчилгээг мэргэжлийн байгууллагуудаар хийлгэж байна. Нөгөө талаар оношилгооны тоног төхөөрөмжийн сэлбэг үнэ ихтэй, олдоц багатай байдаг нь эмнэлгийн төсөвт хүндрэл учруулсаар ирсэн байна.

Тоног төхөөрөмжийн инженерүүдийн ажлын ачаалал харилцан адилгүй, ажил үүргийн хуваарийг гарган батлуулаагүй дутагдал илэрлээ.

Тоног төхөөрөмжийн инженерүүд нь эрүүл мэндийн салбарын эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн нэгдсэн санд зөвхөн 155 тоног төхөөрөмжийг бүртгэсэн, эмнэлгийн тоног төхөөрөмжийн төлөвлөлтийгнэгжүүдээс авсан судалгаа тооцоонд тулгуурлан хийдэггүй, зарим тоног төхөөрөмжүүдийн техник ашиглалтын паспортхөтлөгдөж дууссан байхад шинэчлээгүй байна.

В.3 Шинээр нийлүүлэгдсэн үндсэн хөрөнгийг ашигласнаар эмнэлгийн үйлчилгээнд ахиц, үр дүн гарч байгаа ч нэн шаардлагатай зарим тоног төхөөрөмжийг олж бэлтгэх шаардлагатай байна.

Тайлант онд нийлүүлэгдсэн багаж тоног төхөөрөмжүүдээс сэхээн амьдруулах тасагт хуваарилагдсан дифиберлиатор, дотрын тасагт хуваарилагдсан утлагын

аппарат зэргийг одоогоор ашиглаагүй, бусад тоног төхөөрөмжийг бүрэн ашиглаж байна. Тухайлбал:

- ✓ Утлагын 1 аппарат, автомат тариурын 3шахуурга, зүрхний цахилгаан бичлэгийн 2 аппарат, монитор зэрэг тоног төхөөрөмжийг хүүхдийн тасагт ашиглаж байна. Автомат тариурын шахуурга нь байнгын цахилгаан гүйдэлд залгаатай байдаг, эвдэрч гэмтэхдээ амархан, хүүхдийн тасагт энэ тоног төхөөрөмжийн эрэлт хэрэгцээ байсаар байна. Мөн нярайн шарлагын аппарат, нярайн баталгаат жин дутагдалтай, хүүхдийн тасгийн агааржуулалтын систем шаардлага хангаагүй байгаа гэсэн тайлбарыг эмч мэргэжилтнүүд өглөө.
- ✓ Цусны бүлэгнэлт хэмжигч INR багажийг амбулаторид зүрх судасны эмч ажиллуулдаг. Энэ тоног төхөөрөмжийн оношлуур бодис нь үнэтэй, хүрэлцээ муутай байдаг байна.
- ✓ Диализийн аппарат, ус цэвэршүүлэх системийг ашиглан 2017 оны 3 дугаар сараас хойш 600 өвчтөнд эмчилгээ хийн бөөрний үйл ажиллагааг сэргээсэн. Энэ тоног төхөөрөмжийг суурилуулснаар орон нутагт бүх төрлийн хордлого, бөөрний цочмог болон архаг дутагдал, бөөрнөөс шалтгаалсан даралт ихдэлт, саа саажилт зэрэг өвчтэй иргэдэд цаг алдалгүй эмнэлгийн тусламж үйлчлгээг хүргэн,иргэдийн Улаанбаатар хотод байрлах 3 дугаар шатлалын эмнэлэгт очин оношилгоо,эмчилгээ хийлгэх шууд болон шууд бус зардал чирэгдлийг багасгаж, өвчтөнд учрах сэтгэл зүйн дарамтыг бууруулсан зэрэг үр дүн гарчээ.
- ✓ Төрөх тасагт автомат дуслын шахуурга,отсос, лабораторид центрифуг, ариутгалын тасагт автомат автоклав, мэдээгүйжүүлэлт эрчимт эмчилгээ яаралтай тусламжийн тасагт амьсгалын аппарат, өндөр жин хэмжигч, сэхээн амьдруулах тасагт унтуулгын аппарат зэргийг хуваарилан ашиглаж эхэлсэн байна. Автомат автоклав нь усаа өөрөө татан, хугацаа, аюулгүй байдлын тохиргоогоо автоматаар хийдэг, багтаамж, хурд сайтай, ариутгасан эд зүйлийг хатаан гаргадаг давуу талтай нь эмнэлгийн эмчилгээ, үйлчилгээний чанарт сайн нөлөө үзүүлж байна. Унтуулгын аппарат нь унтуулах хугацаагаа автоматаар тохируулдаг, орчин үеийн шаардлагад нийцсэн нь сэхээн амьдруулах тасгийн эмчилгээний чанарт эерэг нөлөө үзүүлж байна.

2008 оноос хойш хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн оношилгооны зарим тоног төхөөрөмжийн эмчилгээ үйлчилгээний чанарт хэрхэн нөлөөлж байгааг авч үзвэл дараахь байдалтай байна.

- ✓ 2008 онд нийлүүлэгдсэн 39,9 сая төгрөгийн өртөгтэй ходоодны болон уушигны иж бүрэн дуран, 2014 онд нийлүүлэгдсэн 643,7 сая төгрөгийн ходоодны, бүдүүн гэдэсний, уушигны, урологийн иж бүрэн дуран зэргийг бүрэн

ашигласнаар Улаанбаатар хотод байрлах 3 дугаар шатлалын эмнэлэг рүү явах иргэдийн ачаалал буурсан, хавдрын эрт илрүүлэх оношилгоонд дэвшил гаргасан, үйлчлүүлэгдийн сэтгэл ханамжийг сайжруулсан байна. Гэвч тайлант оны байдлаар ходоодны 1 дуранг засварлуулахаар Улаанбаатар хот руу явуулсан, 2008, 2014 онд нийлүүлэгдсэн ходоодны дурангууд нь орчин үеийн анагаах ухааны хөгжил дэвшлээс хоцрогдсон байгаа нь ходоодны хавдрын эрт илрүүлгийн оношилгоонд сөрөг нөлөө үзүүлж байна. Мөн ходоодны болон бүдүүн гэдэсний дуранг 1 угаагч, ариутгагчид угаадаг, ходоодны дуранг урсгал усаар угаах нөхцлийг бүрдүүлээгүй, дурангуудыг хадгалах ариун шүүгээ байхгүй байгаа зэрэг эрүүл ахуйн болон халдвар хамгааллын дэглэмийг зөрчсөн байна.

- ✓ 2013 онд нийлүүлэгдсэн 54,6 сая төгрөгийн өртөгтэй эхо аппарат нь сул зогсолтгүй, байнгын ачаалалтай ажилладаг ч үйлчлүүлэгч иргэдийн оочер дарааллыг бууруулж чадахгүй байна. Тайлант онд дүрс оношилгооны чиглэлийн 3 их эмч ажилласан ч эхоны аппарат дутагдалтайгаас шалтгаалан эмч нарын ажлын ачаалал харилцан адилгүй байна. Иймд орчин үеийн шаардлагад нийцсэн чанар сайтай зөөврийн эхо аппаратыг бэлтгэн ашигласнаар хэвтрийн дэглэмтэй өвчтөнд үзүүлэх эмнэлгийн үйлчилгээний чанар сайжран, иргэдэд учирч байгаа оочер дарааллын бэрхшээл буурах боломж байна.
- ✓ 2009 онд ашиглалтанд орсон 133,3 сая төгрөгийн өртөгтэй рентгэн аппаратны хоолой нь эвдэрсэн, зөөврийн рентгэн аппарат байхгүй байгаа зэрэг нь оношилгоо шинжилгээний чанарт сөргөөр нөлөөлж байна. Рентгэн хоолойны гэмтээс шалтгаалан рентгэн туяа орчинд алдагдах эрсдэлтэй тул “Цөмийн энергийн тухай” хуулийг хэрэгжүүлэн жил тутам ажлын байрны цацрагийн туяаны алдагдлын түвшинг хэмжүүлэх шаардлагатай байна. Мөн зөөврийн рентген туяаны аппараттай болсноор аймгийн түвшинд сүрьеэ өвчний эрт илрүүлгийг сайжруулах боломжтой
- ✓ 2014 онд ашиглалтанд орсон 895,0 сая төгрөгийн өртөгтэй компьютертомографийн аппаратаар 1400 өвчтөнд компьютерийн оношилгоо хийсэн бөгөөд 2016 онд тодосгогчтой томографийн шинжилгээг хийдэг болжээ. Энэ тоног төхөөрөмж нь тархины цус харвалттай, хавдартай, бүх төрлийн гэмтэлтэй өвчтнийг түргэн шуурхай цаг алдалгүй оношлон, Улаанбаатар хотод байрлах 3 дугаар шатлалын эмнэлэг рүү явах иргэдийн зардал чирэгдлийг бууруулж байна. Уг тоног төхөөрөмжийг байрлуулсан өрөөний агааржуулалтын систем хангалтгүй, рентген туяа алдагдахаар байрлалд тоног төхөөрөмжийг суурилуулсан, өвчтөн болон ажиллагсдын орох гарах урсгал буруу байдлаар зохион байгуулагдсаныг эмнэлгийн удирдлагаас анхааран шийдвэрлэх шаардлагатай байна.

ДҮГНЭЛТ: Нэгдсэн эмнэлгийн тусламж, үйлчилгээний хамралт хүртээмж өссөн байна.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР БӨГӨӨД
ДАРГА

Л.УЛАМБАЯР

Зөвлөмж

Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга Ч.Дэмчигсүрэнд

1. Эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, эрүүл мэндийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох талаар санал боловсруулж, аймгийн Засаг даргаар батлуулж байх.
2. Орчин үеийн шаардлагад нийцсэн, чанар сайтай зөөврийн эхо, зөөврийн рентген аппарат, ходоодны иж бүрэн дуран, дурангийн угаагч ариутгагч, дуран хадгалах ариун шүүгээ, нярайн шарлагын аппарат зэргээр нэгдсэн эмнэлгийг хангах саналыг Эрүүл мэндийн яам, аймаг орон нутгийн удирдлагад хүргүүлэн шийдвэрлүүлэх
3. Монгол улсын эрүүл мэндийн сайдын 2017 оны 01 сарын 04-ний өдрийн Өрхийн эрүүл мэндийн төвийн дүрмийг шинэчлэн батлах тухай А/04 тоот тушаалыг хэрэгжүүлэх талаар арга хэмжээ авч ажиллах.

Аймгийн нэгдсэн эмнэлгийн дарга Г.Цогзолмаад

1. Нэгдсэн эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандартын хэрэгжилтийг ханган ажиллахын тулд мэргэшүүлсэн эмч эмнэлгийн ажилтны орон тоог нэмэгдүүлэх саналыг холбогдох яаманд хүргүүлэн шийдвэрлүүлэх
2. Эмнэлэгийн дотоод аудит хяналт-шинжилгээ, үнэлгээний багийн ажлыг эрчимжүүлж, биелэлтийг хянаж ажиллах.
3. Чанарын албаны жилийн ажлын төлөвлөгөөг гаргахдаа Монгол улсын шадар сайд, эрүүл мэндийн сайдын хамтарсан 2012 оны 25 тоот тушаалд заасан үйл ажиллагааны чиглэлд уялдуулах, чанарын хяналт хийсэн ажлуудыг баримтжуулан, нотлох баримтуудыг архивын хуулийн дагуу эмхэлж, цэгцлэх.
4. Тоног төхөөрөмжийн инженерүүдийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, ажил үүргийн хуваарь гарган мөрдүүлэх
5. Багаж тоног төхөөрөмжүүдийн техник ашиглалтын паспортыг шинэчлэн, хөтлөлтөнд хяналт тавих, эрүүл мэндийн салбарын эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн нэгдсэн санд мэдээллийг бүрэн оруулах үүргийг тоног төхөөрөмжийн инженерүүдэд хүргүүлэн, үр дүнд хяналт тавих

6. 2019-2020 онд шинээр бэлтгэх, засвар үйлчилгээ хийх тоног төхөөрөмжийн жагсаалтыг нэгжүүдээс авсан санал, судалгаанд суурилан бодитой төлөвлөх
7. Хүүхдийн тасаг, томографийн өрөөний агааржуулалтын системийг сайжруулах, рентген хоолойг яаралтай засварлуулах, ходоодны дуранг урсгал усаар угаах нөхцлийг бүрдүүлэх, томографийн өрөөний орох гарах урсгалыг зөв чиглэлд оруулах
8. Орчин үеийн шаардлагад нийцсэн, чанар сайтай зөөврийн эхо, зөөврийн рентген аппарат, ходоодны иж бүрэн дуран, дурангийн угаагч ариутгагч, дуран хадгалах ариун шүүгээ, нярайн шарлагын аппарат зэргийг бэлтгэх саналыг Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн яам, аймаг орон нутгийн удирдлагад хүргүүлэн шийдвэрлүүлэх
9. Жил тутам ажлын байрны цацрагийн туяаны алдагдлын түвшинг мэргэжлийн байгууллагаар хэмжүүлэн илэрсэн зөрчлийг бууруулж хэвших .

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР БӨГӨӨД
ДАРГА

Л.УЛАМБАЯР